



ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ (Эрүүгийн хэрэг¹)

ЭРҮҮГИЙН ХУУЛИАР ОНОГДУУЛСАН ЖОЛООДОХ ЭРХ ХАСАХ НЭМЭГДЭЛ ЯЛЫГ ЗӨРЧЛИЙН ШИЙТГЭВРЭЭР ХҮЛЭЭЛГЭСЭН ЭРХ ХАСАХ ШИЙТГЭЛИЙГ БИЕЛҮҮЛЖ ДУУССАНЫ ДАРАА ЭДЛҮҮЛНЭ ГЭЖ ДҮГНЭСЭН НЬ БУРУУ ГЭЖ ҮЗЭВ

САНАМЖ: Энэхүү хураангуй нь шүүхийн шийдвэрийг орлохгүй ба хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтооход дэмжлэг үзүүлэх, шүүхийн шийдвэрийн үндэслэлийг сурталчлах болон иргэд, олон нийтийн эрх зүйн мэдлэгт зориулсан бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь хяналтын шатны шүүхийн тогтоол болно.

Шүүхийн шийдвэрийн дугаар: 2025/ХШТ/118

Шүүхийн шийдвэрийн огноо: 2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр

Шийдвэрийн төлөв: Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол, давж заалдах шатны шүүхийн магадлалд өөрчлөлт оруулсан.

ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

Шүүгдэгч нь тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан үедээ согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодон замын хөдөлгөөнд оролцсон гэмт хэрэгт холбогджээ.

ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

1. **Анхан шатны шүүхээс** шүүгдэгчийг тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан үедээ согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодон замын хөдөлгөөнд оролцсон гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, Эрүүгийн хуулийн 27.10 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт² зааснаар тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 1 жилийн хугацаагаар хасаж, 2,700 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэж, Эрүүгийн хуулийн 5.7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт³ зааснаар тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 1 жилийн хугацаагаар хасах ялын хугацааг өмнөх зөрчлийн шийтгэврээр оногдуулсан тээврийн хэрэгсэл

¹ Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос:

https://shuukh.mn/single_case/3789?daterange=2024-01-01%20-%202026-01-09&id=3&court_cat=2&bb=1, (Сүүлд үзсэн: 2025.01.12).

² Эрүүгийн хууль (2015)-ийн 27.10 дугаар зүйлийн 5 дахь хэсэг “тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан хүн согтуурсан, мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, эсхүл согтуурсан, мансуурсан эсэхийг зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн бол тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар хасаж хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ”

³ Эрүүгийн хууль (2015)-ийн 5.7 дугаар зүйлийн 3 дахь хэсэг “шүүх эрх хасах ялыг хорих ял дээр нэмж оногдуулсан бол уг ялыг эдэлж дууссаны дараа, эсхүл торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах ял дээр нэмж оногдуулсан бол ял оногдуулсан үеэс, эсхүл хорих ял оногдуулахгүйгээр үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авсан бол албадлагын арга хэмжээ авсан үеэс хугацааг тоолно”



жолоодох эрх хасах шийтгэлийн хугацаа дууссан үеэс эхлэн тоолохоор шийдвэрлэжээ.

2. **Давж заалдах шатны шүүхээс** анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж, прокурорын эсэргүүцлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.
3. **Прокурор хяналтын шатны шүүхэд бичсэн эсэргүүцэлдээ** “...шүүгдэгчид Эрүүгийн хуулийн 27.10 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт зааснаар тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 1 жилийн хугацаагаар хассан нэмэгдэл ялыг зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны журмаар оногдуулсан эрх хасах шийтгэлийг эдэлж дууссан үеэс эхлэн тоолохоор шийдвэрлэсэн нь үндэслэлгүй. Эрүүгийн хуулийн 5.7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаас үзэхэд эрх хасах ялыг зөрчлийн шийтгэлийг эдэлж дууссан үеэс тоолохгүй, харин шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон үеэс эхлэн тоолох нь зүйтэй. Анхан болон давж заалдах шатны шүүх нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.3-т⁴ зааснаар хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн байх тул тогтоол, магадлалд шүүгдэгчид оногдуулсан жолоодох эрхийг 1 жилийн хугацаагаар хасах ялын хугацааг торгох ял оногдуулсан үеэс тоолсугай гэсэн өөрчлөлт оруулж өгнө үү” гэжээ.
4. **Хяналтын шатны шүүхээс** хоёр шатны шүүхийн хийсэн дүгнэлт шийдэл, оногдуулсан үндсэн болон нэмэгдэл ялын төрөл, хэмжээ нь хууль ёсны, үндэслэлтэй болжээ. (12)⁵
5. Харин Эрүүгийн хуулийн 27.10 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт зааснаар шүүгдэгчид тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 1 жилийн хугацаагаар хасаж, 2,700 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэхдээ **эрх хасах нэмэгдэл ялыг зөрчлийн шийтгэврээр хүлээлгэсэн эрх хасах шийтгэлийг биелүүлж дууссаны дараа эдлүүлэхээр тогтоож Эрүүгийн хуулийн 5.7 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг буруу хэрэглэсэн байна.** (13)
6. Эрүүгийн хуулийн 27.10 дугаар зүйлийн 5 дахь хэсэг дэх “тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан хүн” гэдгийг согтуурсан, мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, эсхүл согтуурсан, мансуурсан эсэхийг зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн үйлдлийн улмаас тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан хүн гэж ойлгохоор тухайлан тайлбарлажээ. (14)
7. Хуулийн зохицуулалтаас үзэхэд дээрх гэмт хэргийг үйлдсэн хүн өмнө нь Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 5.1, 5.2, 5.3-т⁶ заасан үндэслэлээр тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл хүлээсэн

⁴ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.7 дугаар зүйлийн 1.3 дахь хэсэг “хуулийн зүйл, хэсэг, заалтыг буруу тайлбарлаж хэрэглэсэн бол Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн гэж үзнэ”

⁵ “Хууль хэрэглээ, шүүхийн шийдвэр” хэсгийн өгүүлбэрийн төгсгөлд бичигдсэн хаалт доторх дугаарлалт нь шүүхийн эх шийдвэрийн цогцолборын дугаар болно.

⁶ Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 5.1, 5.2, 5.3 дахь хэсэг “жолооч согтуурсан, мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон; тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй, эсхүл жолоодох эрх нь дуусгавар болсон хүн согтуурсан, мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон; согтуурсан, мансуурсан эсэхийг зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг нэг жилийн хугацаагаар хасаж дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна”



- бөгөөд эрх нь хасагдсан хугацаанд тухайн төрлийн зөрчлийг давтан гаргасан бол гэмт хэрэгт тооцно. (15)
8. Эрүүгийн хариуцлага болон зөрчлийн шийтгэлийн аль аль нь нийтийн эрх зүйн хүрээнд хөндөгддөг боловч үндсэн зорилгоороо ялгаатайн гадна харилцан бие биеэ нөхөх шинжтэй. Иймд эрүүгийн болон зөрчлийн хариуцлага нь үндсэн зорилгын хүрээнд хамт хэрэглэгдэхгүй. (16)
9. Түүнчлэн, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, эдгээрийн шийдвэр гүйцэтгэх журмыг тусдаа бие даасан хуулиар зохицуулсан байхад анхан болон давж заалдах шатны шүүхүүд эрүүгийн хариуцлага, зөрчлийн шийтгэлийг хамтад нь биелүүлэхээр шийтгэх тогтоолоор заасан нь буруу болжээ. (17)
10. Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 5.1, 5.2, 5.3-т заасан үндэслэлээр тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл хүлээсэн хүн шүүхийн шийтгэвэр хүчин төгөлдөр болсны дараа, эрх хассан хугацаанд тухайн төрлийн зөрчлийг давтан гаргасан бол сүүлийн үйлдэл нь Эрүүгийн хуулийн 27.10 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан гэмт хэрэгт тооцогдож, эрүүгийн хариуцлага хүлээх тул шийтгэврийн биелэлтийн талаар дүгнэлт өгөх хууль зүйн үндэслэл үүсэхгүй болно. Өөрөөр хэлбэл, эхний үйлдэлд хүлээлгэсэн зөрчлийн шийтгэврийн биелэлт нь давтан буюу хоёр дахь удаагийн үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд хамаарахгүй бөгөөд эдгээр хариуцлагууд нь тус тусдаа шийдвэр гүйцэтгэх журмын дагуу биелэгдэх ёстой. (18)
11. Иймд прокурорын бичсэн эсэргүүцлийг хангаж, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.4-т⁷ заасны дагуу шийтгэх тогтоолд “Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 5.7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг баримтлан шүүгдэгчид оногдуулсан тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 1 жилийн хугацаагаар хасах нэмэгдэл ялын хугацааг торгох ял оногдуулсан үеэс тоолсугай” гэж өөрчилж, шийтгэх тогтоол, магадлалын бусад заалтыг хэвээр үлдээж шийдвэрлэжээ. (21)

---o0o---

⁷ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.8 дугаар зүйлийн 1.4 дахь хэсэг “хяналтын шатны шүүх нь хэргийн зүйлчлэл, ялыг хүндрүүлэхгүйгээр анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах шийдвэр гаргана”